

МОНГОЛЫН ТӨРТ ЁСНЫ УЛАМЖЛАЛААС

Ц.ГАНБОЛД

Доктор профессор, МУИС, ШУС, Нийгмийн Ухааны Салбарын захирал

Л.ИДЭР

Докторант

Түлхүүр үг: Төр. Уламжлал, хоёр ёсны сургаал, төр барихуйн арга ухааны уламжлал

Хураангуй: Монголчууд өөрийн анхны төр улсаа байгуулан төр барих үзэл баримтлал, ёс заншил, нийгмийн хэм хэмжээг бий болгон улам төгөлдөржүүлэн бататгаж ирсэн байдаг. Монголын төр барих арга ухааны уламжлал болоод түүний үзэл санааг шинжлэн судлах нь туйлаас чухал юм. Монголын төрийн түүхийн нэг оргил сурвалжийн нэг нь “Дөрвөн төрийн арван буянт номын цагаан түүх” хэмээх хууль цаазын бичиг юм. “Дөрвөн төрийн арван буянт номын цагаан түүх” хэмээх хууль цаазын бичигт төр, шашны харьцаа, хоёр ёсны тухай, төрийн түшмэдийн эрдэм ухаан, цээрлэх, эрхэмлэх зүйл зэргийг заасан нь монгол төрийн ёсонд уламжлагдах учиртай.

Краткий обзор: С тех пор, как Монголы создали свою государственность, сформировались их политические нормы, взгляды и традиции улучшались последующее время. Очень важным считается исследование идей, традиций и методов управления государством. Одним из замечательных источников периода расцвета Монгольского государства является произведение под названием “Дөрвөн төрийн арван буянт номын цагаан түүх” (“Белая история десяти благородных книг четырёх государств”). В этом произведении говорится об отношениях между государством и религией, о двух законах, об образовании, о моральных ценностях государственных чиновников и все это должно сохраниться в традициях монгольской государственности.

Манай Монгол улс бол төр засаглалын өнө эртний уламжлалтай орон билээ. Төр бол хүний нийтлэгийн амьдралыг зохицуулах, зохион байгуулах арга хэлбэр бөгөөд нийгмийн амьдралын амин чухал хэрэгцээ шаардлагаар буй болсон, соёл иргэншлийн үнэт зүйл мөн ажээ¹.

Түүхээс үзвэл МЭӨ III зууны үед мандсан Хүннү улс нь өөрийн нутаг дэвсгэртэй, хил хязгаартай, өөрийн хүн амтай, хаантай, аравтын ёсыг үндэс болгосон, нутаг орноо захирах тогтолцоотой, дайчин гавшгай морьт цэрэгтэй, хууль цаазтай, бие даасан гадаад харилцаатай, улс хэмээх нь байтугай эдүгээ гүрэн хэмээн яригддаг төрийн том бүрдэл байсан байна. Монголын түүхэн сурвалжуудад төр барих үлгэр жишээ гэмээр олон зарчим, үйл явдлыг тусгасан байдаг. Аль нэг орны хараат, эрхшээлд байгаад, ХХ зууны 60-аад оноос тусгаар улс болсон олон орон тэр үеийг хүртлээ нэгдсэн төр улс болж зохион байгуулагдаж байгаагүй, овгийн хэлбэрээр оршин тогтнож ирсэн юм. Тэгэхлээр тийм хүмүүсийн олонлог бол “төрийн чанаргүй” хүмүүсийн нэгдэл байжээ. Төр барих ажил нь ан гөрөө гэх мэт бусад ажлаас тасарч салаагүй, мэргэжлийн бус, тийм болохоор төр барьдаг тусгайлсан хүмүүс ч үгүй байсан хэрэг. Тэд бол төр ёсны уламжлалгүй гэж хэлэгдэж болох юм². Ийм байр сууринаас авч үзвэл төрт ёс хэмээх эл ойлголт илүү өнгөрсөн цаг руу чиглэсэн, тухайн ард түмэн нэлээд урт хугацаанд төрийн хэлбэрээр зохион байгуулагдаж байсан түүхтэй, энэ явцад зохих хэмжээний бүрдэл, хэм хэмжээ буй болон хэрэглэгдэж уламжлагдаж ирсэн гэсэн санааг илэрхийлдэг хэмээн ойлгож болох юм. Иймд “төр” хэмээх ойлголт нь их өргөн агуулгатай, монголчууд төрийн тухай ихэд гүнзгий мэдлэг ойлголттой байжээ. Бидний Монголчууд одоо мэдэгдэж байгаагаар хоёр мянга гаруй жилийн тэртээгээс Монгол нутагт оршин байсан нүүдэлчдийн улсуудын төр ёсыг өвлөн авч, улс гэрээ авч яваа төрт ёс бүхий орон. Төр ёсыг сахих үзэл манай ард түмний ахуй ухамсарт гүн шингэж орсон зүйл болно. Тиймээс Монголчууд төрөө хүндэтгэж олон үйлийг хийхдээ ёс төртэй хийхийг эрмэлздэг билээ. Эзэн богд Чингис хаанаас эхлэн түүний залгамжлагчид янз бүрийн үндэсний мэргэдийг дэргэдээ авч, тэдний мэдлэг, туршлагаас өөрсдөө хэрэгтэй гэснийг тунгаан авч, монгол төр ёс, зан заншилдаа нийцүүлэн хэрэглэж байжээ. Мэргэдийг шадарлуулж, эрдмийг нь ашигладаг байсан, хүний сайн арга ухааныг өөрийн болгож боловсруулан хэрэглэдэг байсан нь монгол хаадын суу юм³.

Тэр болгон нь өөрсдийн нь үүтгэл бүтээлтэй нэгдэн нийлж монголын төр ёсны уламжлалыг бүрдүүлжээ гэж болно. Нэгдмэл төр улсгүй байсан анчин, загасчин овог аймгууд орчин үеийн ертөнцийн ёсыг дагаж сая нэг төр улсаа байгуулаад түүнийгээ хэрхэн авч явахаа мэдэхгүй өөр зуураа хагаралдан

¹ М.Санждорж “Монгол төрийн түүхээс” УБ.,1998 он, 10 дахь тал.

² Цанжид А. “Төр барихуй Монгол ухаан” УБ.,2011 он, 9 дэх тал

³ Цанжид А. “Төр барихуй Монгол ухаан” УБ.,2011 он, 12 дэх тал.

элдэв янзаар будилж байх нь элбэг. Гадаадынхан түүнийг хараад дооглох, бас ч далимдуулан ашиг хонжоо хайх нь ч элбэг тохиолддог. Энэ бол мөнөөх төр ёсны бүрэлдэхүүн хэсэг болох төр барих ухаан, уламжлал дутаж байгаагийн шинж болой. Өвөг дээдэс маань төр улсаа төвхнүүлэн, хамгаалан тордож өдий хүргэхдээ төр барих монгол ухааныг боловсруулан хэрэглэж иржээ. Тэрхүү ухаан Монголчуудтай олон талын харилцаатай байсан бусад үндэстний төр ёсонд ч нөлөөлсөн явдал бий. Одоо ч гэсэн Хүннү, Монголын хаад, ялангуяа Атилла, Чингис нарын төр барих ухааныг дэлхий дахинаараа судалсаар байна. Монголчууд төрт ёсныхоо уламжлалыг хойч үедээ эзэмшүүлэн улс орноо даатгадаг бичигдээгүй хуультай байсан аж. Засаг төрийн хэргийг ардчиллын ёсонд нийцүүлэн буй одоо цагт ч төрт ёсны уламжлалаа эргэн санаж хэрэглэх нь төр улсын маань хөгжил цэцэглэлд нэн хэрэгтэй юм.

Ардчилал гэж нэрлэгдэж буй аль ч орон төрт ёсны уламжлалаа дагадаг, өөрийн онцлогтой байгааг санууштай. Мянган жилээс илүү гарч тоологдох урт хугацааны төрт ёсны уламжлалтай цөөхөн улсын нэг нь даруй манай Монгол мөн билээ. Тийм болохоор төр барихуйн хямрал бүхий өнөө цагт төр ёсны арвин их уламжлалаа уудлан сэргээж, түүнд авах гээхийн ухаанаар хандан Монгол төр улсын оршин тогтнохуйтай баг холбоотой төр барихуйн ухаан, уламжлалыг сэргээн хэрэглэх нь мөн ч тустай юм. Удаан хугацааны төрт ёс бүхий аль ч улс орны төрийн түүх хаант засгаас эхлэлтэй. Хаан төрийн тулгуур нь язгуурнууд байсан түүхтэй. Тэд төрийн түшмэл, цэргийн эрхтэн байж төр улсаа зохион байгуулж, хамгаалан бэхжүүлэхэд зүтгэдэг байсан. Тийм ч учраас төрт ёсны уламжлалыг хамгийн сайн мэднэ. Монгол оронд ч Чингис хааны үеэс эхлэн ХХ зууны эх хүртэл тайж язгууртнууд монгол төрд томоохон үүрэг гүйцэтгэсээр ирсэн билээ. Монголын төрт ёсны үзлийн уг эх нь Хүннү улсаас наашлаж монгол нутагт байсан монгол, түрэг угсааны улсуудаар дамжин Монголын эзэнт гүрэн хүртэл үргэлжилж ирсэн ба Чингис хаан түүний залгамжлагчдын үйл хэрэг, үг сургаалаараа, Их засаг бусад хуулиараа нарийвчлан боловсруулжээ. Тэрхүү суурин дээр төр ёсны үзлийн цаашдын хөгжил үргэлжилсэн байна. Энэ үед нэг талаас Күнзийн бичгийн ёс, нөгөө талаас бурхны шашны номын ёс нөлөөлж төрт ёсны уламжлал бүрэлдэн биежжээ. Монгол төрийн түүхэн замналдаа олсон нэгэн чухал суртал бол аливаа үзэлд туйлшрахгүй “ертөнцийн ёсонд” нийцүүлэхийг эрхэмлэж байсан явдал бүлгээ. Төр ёсны нэг зарчим бол “мөнх тэнгэрийн хүчинд, хааны суу зальд” хэмээх юм. “...төр засгийн тухай монголчуудын үзэл баримтлалд хоёр зүйлийг эрхэмлэн үзэж байсан бөгөөд түүнийг нь нэгэн төрлийн хос ёсны үзэл ч хэмээн нэрлэж болмоор байгаа юм.” Ийм хос ёсны үзэл зөвхөн хаан төрийн тухайд ч бус аливаа зүйлийн тухай монголчуудын үзэлд шингээстэй явж иржээ. Туйлшралгүй байх, ертөнцийн ёсонд нийцүүлэх нь монголын түүхийн нэн эртний үеэс ажиглагддаг үндэслэл бөгөөд түүнд суурилсан хос ёсны үзэл нэвтэрсэн ч байж болох юм. Хос ёсны үзэл нь хэдийгээр түүхэн тодорхой цаг үед төр, бурхны шашны харилцаа, төрийн хэргийг явуулахад тэдгээрийн үүрэг оролцооны тухай асуудлыг хөндөж гарч ирсэн тодорхой үзэл баримтлал боловч ертөнцийн ёсонд нийцүүлэх тухай монгол үзэл санаатай амьсгаа нэгэн зүйл гэж болох юм. Чингисийн билигт хүний сэтгэлийг эзэмдвэл бие нь хаа олох гэх мэт сургаал байдгийн тулгуур үзэл санаа нь хос ёсны үзэлтэй ижил юм. “Хотгойд Дэлгэрмөрөнгийн хүрээний “нийцийн аграмба багш” хэмээх Цэрэнжавын төвд хэлээр бичсэн “Шар, хар нийгэд эс дэлгэрсэн чухал хэрэгтэй үгсийн тэмдэглэл” хэмээх сударт багшаасаа нэгэн шавь нь Бурхны шашин, хааны төр хоёрыг юугаар нь ялгаж таних вэ? гэж асуусанд, багш нь хариулж хэлэхдээ: “Өөртөө харгацсанаас, өөрийн сэтгэлийн үндсэнд буй арван нүглийг тэвчих нэгэн зүйл ёс зарчим буй, тэр бурхны шашин мөн. Өрөөлд харгацсанаас, арван хар нүглийг хорин тэвчүүлэх нэгэн зүйл засаглал буй, тэр нь хааны төр мөн.” гэжээ. Энэ бол нэг нь дотроос засдаг, нөгөө нь гаднаас нь засдаг гэсэн үг. Өөрөөр хэлбэл нэг нь ухамсарлахад түшиглэдэг, нөгөө нь хүчирхийлэлд түшиглэдэг гэсэн үг. Өөрөөр хэлбэл сайнд хөтлөх, саарыг тэвчүүлэх үйлийн хүрч нийлэх үзүүр нь хоёул адил, хүргэж аваахих хөлөг унаа нь хоёул өөр гэсэн үг. /Хүрэлбаатар Л, 25-26 дахь тал/. Ийнхүү төр улсыг удирдахад ухаанаар болон хүчээр засах нь ертөнцийн ёс болой. Өнөөгийн амьдралд эрх зүйт төрийн зарчмыг хэрэгжүүлж түүний зарчмуудыг янз бүрээр тунхаглаж байна. Гэтэл эрх зүйт төрийн зарчмыг бодож үзвэл түүний ул суурь нь хуулийн хүчирхийлэл юм. Хууль зөрчсөн бол зэмлэл шийтгэл хүлээх нь гарцаагүй.

Удирдлага, сэтгэл зүйн ухаанд сэдэл, кошуучлал мэтийн олон ойлголт бий болж тэдгээрийг тал бүрээс нь судлан хэрэглэх оролдлого хийж байгаа нь дан ганц хүчирхийлэл буюу төрийн хууль цаазын хүчийг ашиглах нь хангалтгүй байгааг илтгэсэн хэрэг юм. Гэтэл хэргийн учир нь угаас хүний мөн чанартай, бидний дээр хэлсэн нэр томъёогоор ярих юм бол ертөнцийн ёстой нягт холбоо бүхий хос ёсонд оршиж байгаа хэрэг юм. Хос ёсны сургаал Энэтхэг-төвдөөс гаралтай нь үнэн боловч монголын төрт ёсонд “шилжин” орохдоо чухамхүү монгол төр ёсны сэтгэлгээний шимт хөрсөн дээр соёлон

⁴ Бира Ш Түүвэр зохиол, УБ., 51 дэх тал.

идээшсэн хэрэг юм. Сэтгэлээс үйл гарна. Үйлээс үр дагавар гарна. Тиймээс үр дагавар бол сэтгэлийн ч үйлийн ч үр мөн гэж болох юм. Муу сэтгэлээс муу үр үүсч, муу үйлээс муу үр дагавар гарна. Муу үйл үйлдэхээс өмнө муу сэтгэлийг засвал муу үйл гарахгүй. Нэгэнт муу үйл үйлдэгдэж муу үр дагавар гарсан бол түүнийг хүчээр зогсоохоос өөр аргагүй юм. Энэ бол ертөнцийн ёс юм. Хоёр ёсыг эртний Самандабадари бодисадвагийн хувилгаан олноо өргөгдсөн хаан байгуулсан бөгөөд тэндээс Төвдийн гурван Загравард хаан уг ёсыг явуулж улмаар Жад Монголын газарт дэлгэрсэн хэмээн өгүүлжээ⁵. Уг гарал нь маргаангүй боловч энэхүү “хос ёс” хэмээх үзэл нь хүний бие сэтгэлийг эзэмдэх тухай монгол хаадын үзэлд суурилан Монголын төрд бурхны шашны нөлөө хүчтэй болсон цагт тодорч үзэл баримтлалын төвшинд томъёологдсон гэлтэй. Энэ нь Монголчуудаас хүн төрөлхтөний улс төрийн сэтгэлгээнд оруулсан жинтэй хувь нэмэр юм. Баримт ноттой зүйлийг түшин өгүүлэх юм бол Хубилай хаан 1264 онд Төвдөд явуулсан Сувд бичиг буюу “Мүдигма” хэмээх зарлигтаа хос ёсны үзлээ тодорхойлсон байдаг байна. Уг зарлигт:

“Мөнх тэнгэрийн хүчинд

Их суу залийн ивээлд

Хааны зарлиг мину.

Тойдод, иргэнээ дуулгахуй нь, энэ хотол төгсөхүйг Чингис хааны засгийн ёсоор явбаас болон бөгөөтөл хойтын тусыг номын ёсноо шүтэх хэмээсэн утгыг шинжилж, бурхан Шагжамунийн энэ мөр чухам ариун хэмээн мэдэж, тэр мөрийг сайтар онон ...” гэх мэтээр бичсэн байдаг байна⁶. “Эдүгээ би бээр түүнчлэнхүү хоёр ёсыг тэгшээр явуулсугай хэмээгээд түүгээр эн урьдад хүрэхүйеэ хоёр ёсыг аль буй хэмээвээс, номын төр тарни судар хоёр хийгээд ертөнцийн төр энх чин хоёр...”⁷ хэмээн хоёр ёсыг баримтлахаа илэрхийлэхийн ялдамд тэр нь юу болохыг тодорхойлсон байна. Арван хар нүглийг дотроос нь тэвчүүлэх үүрэг бүхий номын төр тарни судар хоёр аж. Харин хаан төр ямар үүрэгтэй гэж үзэж байгаа вэ? Цагаан түүх-д “энх чин” гэснийг ухан ойлгоход сэжүүр болох тодорхойлолт буй. “Эртний богдосын байгуулсан хууль үлгэрийн ёсоор, амьтны тусад сайн үгсийг соён сургаж бүрүүн. Энх төрөөр гар газраа, хөл хөсрөө амирлиулбаас улсыг засагч зарлигийн шүтээн хонжин хэмээюү. Их төр чин болохуй цагийн ёсны сэрэл манжил их улсад дуулгаж бүрүүн. Харь дайсныг арга хүчээр даруулан чадваас иргэн оргоныг сахигч зүрхний шүтээн хонжин хэмээюү”⁸. Энэ хэсгийг эрдэмтэн Ш.Чоймаа тайлбарлахдаа “... хааны барих төр ёс буюу энх төр нь бүх нийтийг сурган соёж, гар газраа, хөл хөсрөө амарлиулж, улсыг засах үүрэгтэй ажээ. Харин түшмэлийг барих төр буюу чин төр нь цагийн байдлыг сэрэн болгоож, харь дайснаас сэрэмжилж, ард иргэнийг сахин хамгаалах үүрэгтэй ажээ” хэмээсэн байна. Цагаан түүхийн эл хэсэг болон, Ш.Чоймаагийн тайлбарласнаас үзэхэд төр нь ард олноо сурган соёх, аж амьдралыг нь өөд татах дотоод үүрэгтэй, гадны халдлагаас хамгаалж, амар жимэр амьдруулах гадаад үүрэгтэй гэж үзэж байжээ. Хос ёс нь улс гэрийг засах арга мөн болохоос гадна сайн муу, буруу зөвийг ялгах хэм хэмжээ байжээ. Үүнд,

“Ерд хоёр засгаар эс явбаас

Буян хилэнц хоёр

Хар цагаан хоёр

Хүнд хөнгөн хоёр

Үнэн худал хоёр

Сайн муу хоёр

Жаргал зовлон хоёр

Эдний ялгалыг үл мэдэхүйн тулд

Үнэн номын засаг хивийн зангиа мэт эвдэршгүй

Хүнд хааны төр алтан буулга мэт эвдэршгүй” гэжээ.

Номын болон хааны төрийн аль алиныг чухалд үзэхийн зэрэгцээ тэдгээрийг холихгүй гэсэн санаа Цагаан түүхэнд хэд хэдэн удаа давтагдсан байх аж. Жишээ нь “Хоёр ёсыг холилгүй тус бүр тогтоогдох дунд бүхий хөдлөхүйн дээд их хөх Монгол улс, дорно Солонгос, Битэгүд хоёр улс, өмнө Хятад Хилюед хоёр, өрнө Балба Сартуул хоёр, Умар Ташиг Төвд хоёр, таван өнгө дөрвөн харь есөн их улсад айх мэт тунхаав”⁹. “Цагаан түүх” нь номын төр талдаа бурхны шашны уламжлалд тулгуурлаж, хааны төр талдаа монгол төрийн уламжлалд тулгуурласан гэж болох юм. Энэхүү төр шашнаар улсыг засах хос ёсны үзлийг Монголчууд чухамдаа социалист үеийг хүртэл баримталж ирсэн шинжтэй байдаг. Алтан хааны

⁵ Арван буянт номын цагаан түүх. Монголын түүхэн сурвалж бичгийн 2-р боть, УБ.,2006 он, 19 дэх тал.

⁶ Чоймаа Ш “Хос ёсны сургаалаар төрөө засаж ирсэн уламжлал” итгэл, 8 дахь тал.

⁷ Арван буянт номын цагаан түүх. Монголын түүхэн сурвалж бичгийн 2-р боть, УБ.,2006 он, 23-24 дэх тал.

⁸ Арван буянт номын цагаан түүх. Монголын түүхэн сурвалж бичгийн 2-р боть, УБ.,2006 он, 27 дахь тал.

⁹ Мөн тэнд 31 дэх тал.

цаазад “Одоогийн хоёр ёсноос: Номын цааз хэвийн зангиа мэт эвдэршгүй очир, хааны цааз Алтан буулга мэт сүр жавхлан ихтэй бээр, агуу улс орон бүхэнд түгсэн хоёроос хааны цааз ашдын цааз их өчүүхэн аль алиныг зохистойгоор энэ мэт зохиов” гэжээ¹⁰. Энэ бүхнийг судлахын учир нь хос ёсны үзэл, уламжлалыг ойлгох явдал юм. Хос ёсны зарчмын сэтгэлийн үйлийн холбооны тухай суурь үзэл санаа нь төрийн албанд хүнийг шилэн сонгож тавихад ч холбогдолтой юм. Өрнөдийн судлаачид төрийн алба хаах эрмэлзлэлтэй хүмүүсийн нэлээд нь “бусдын төлөө” гэсэн сэтгэлтэй байдгийг судлаж тогтоосон тухайгаа бичсэн байдаг. Бусдын төлөө буюу нийт нийгмийн сайн сайхны төлөө гэсэн сэтгэлээс хүнд суртал, авилга биш жинхэнэ “төрийн дам нуруу” болох хүний үйл төрнө гэдэг нь ойлгомжтой юм.

Хос ёсны сургаал монголын эртнээс нааш баримталж ирсэн аливаа үйлийг ертөнцийн ёсонд нийцүүлэх үзэл санаанд суурилахын зэрэгцээ илүү том хүрээгээр бодож нэгтгэн дүгнэсэн зарчим болон хөгжсөн байна. Энэ талаар эрдэмтэн Ч.Дэмчигдоржийн улсын их хуралд бичсэн захидалд нэн тодорхой тайлбарлажээ. Түүний бичсэн нь “... ер язгуурын суртахуун хэмээгч хүний сэтгэлийг дотуураар гэгсгээж мууг тэвчүүлэн сайнд давшуулах дүрсгүй дотоод утга гэгээний ёсон болой. Засгийн ёсон хэмээгч улс төрийг баян чийрэг болгох гадаад дүрс бүхий утга гэгээний ёс болой. Үүнд дан ганц гадаад үзлийн ёсыг эрхэлж дотоод сэтгэлийг засах үнэн магад ёс эрдмийг гээх болвоос хорлол үүнээс үлэмж нь үгүй. Үүнд улс төр хэдий баян чийрэг болвой хэмээн ямар тус аж”¹¹. Дотоод сэтгэлийг засах үнэн магад ёс хэмээгчид бурхны шашны гол байр эзлэх боловч үндэсний ёс заншлын шилдэг уламжлал мөн багтах юм. Ертөнцийн бүхий л юмны түгээмэл холбоо, уг холбоонд үндэслэсэн жам ёсны тухай тэнгэр үзэл, түүнтэй нягт холбоотой хүний явдлыг ертөнцийн ёсонд нийцүүлэх тухай болон дотроос нь сэтгэлийг нь засах, хууль цаазаар гаднаас нь засах тухай хос ёсны үзэл, ертөнцийн тогтолцоо болон үйлдэхүйн зарчмыг заадаг арга билгийн ёсон, орчлон хорвоогийн орчихуй өөрчлөгдөхийг даган хувьсах авах гээхийн ухаан зэрэг нь монголын төрт ёсны гүн ухааны өөр хоорондоо нягт холбоотой, янз бүрийн цаг үед гарч бие биеэ нөхөн дүүргэсэн цогц ухаан юм. Энэ бүхний гол санаа нь төвч үзлээр илэрхийлэгдэх амуй. Тэгэхдээ энэхүү төвч нь шууд бурхны шашны гүн ухаанаас, түүнээс дангаар нь бус ерөөс монголын төрт ёсны уламжлалыг бүгдийг багтаасан ойлголт юм. Туйлшрахуй нь жам ёсноос ямагт гажиж хазайхад хүргэх ба жам ёсыг ухан барьж үйлдэх нь төвч байр сууринд бэхэлмүй. Төвч байх нь аливаа юмыг гүн гүнзгий угт нь тултал бодож тунгаах угтвар, түүнд суурилсан төвшин үйлдэхүйг зайлшгүй шаардана. Чухам энэ л монгол төрийн ухааны охь юм. Монголын төрт ёсны тулгуур үзлүүдийг сайтар судлан мэдэж дэлхийн байдал хийгээд улс орныхоо байдал төлөв, өөрсдийн үйл явдлыг цэгнэн чадвал хөгжин цэцэглэх болон оршин тогтнохын үндэс нэн бат болж монгол уламжлалыг хадгалж үлдэх билээ. Өөрийн төр барихуйн гүн ухааны үзлийг үл мэдэн, эсвэл түүнийг хоцорсон баларсанд тооцож үл тоож хүний үзлээр ухаан хийх нь хүний зохиосон тоглоомын дүрмээр тоглож хожигдохын цондон билээ¹². “Дөрвөн төрийн арван буянт номын цагаан түүх” хэмээх хууль цаазын бичигт төр, шашны харьцаа, хоёр ёсны тухай, төрийн түшмэдийн эрдэм ухаан, цээрлэх, эрхэмлэх зүйл зэргийг заасан нь монгол төрийн ёсонд уламжлагдах ач холбогдолтой байв¹³. Дээрх байдлаас авч үзэхэд төрийн уламжлал шинэчлэлийг зөв зохистой авч үзэж, судлах нь тэргүүн ач холбогдолтой гэдгийг харуулж байна.

НОМ ЗҮЙ

1. Арван буянт номын цагаан түүх. Монголын түүхэн сурвалж бичгийн 2-р боть. УБ.,2006 он
2. Бира Ш Түүвэр зохиол, “Монголд нэгдсэн төр байгуулагдаж феодализм бүрэлдэн тогтсон нь” УБ.,1960 он
3. Ишжамц.Н “Монголд нэгдсэн төр байгуулагдаж феодализм бүрэлдэн тогтсон нь” УБ.,2002 он
4. Монголын төр, эрх зүйн түүх УБ., 2010 он
5. Монголын философийн түүх УБ., 2000 он
6. Санждорж.М “Монгол төрийн түүхээс” УБ.,1998 он
7. Улсын дээд, доод ... 1-р боть
8. Чоймаа Ш “Хос ёсны сургаалаар төрөө засаж ирсэн уламжлал” итгэл Эрдэм шинжилгээний бичиг №2 УБ.,2004 он

¹⁰ Монголын төр, эрх зүйн түүх УБ., 2010 он, 15 дахь тал.

¹¹ Улсын дээд, доод ... 1-р боть, 32 дахь тал

¹² Цанжид А. “Төр барихуй Монгол ухаан” УБ.,2011 он, 61, 62 дахь тал.

¹³ Монгол улсын төр, эрх зүйн үндэс УБ.,2000 он, 57 дахь тал.